

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
3.1	Цалин, ХХОАТ, НДШ талаар /үндсэн/.....	11
3.2	Цалин, ХХОАТ, НДШ талаар /гэрээт/.....	12
3.2.1	Илрүүлэлт:	12
3.3	Зардлын талаар.....	12
3.4	Орлогын талаар.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5	Хавсралт.....	21
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ
ДАРГА, ХУРАНДАА Д.АМАРСАЙХАН
ТАНАА

2019.02.25 № 06/278
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тээврийн цагдаагийн албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тээврийн цагдаагийн албаны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг албаны дарга, цагдаагийн хурандаа Д.Амарсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, зардлын бүртгэл татвар шимтгэлийн тооцооллыг хууль журамд нийцүүлэх тухай зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тээврийн цагдаагийн албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14/165 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Тээврийн цагдаагийн албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тээврийн цагдаагийн алба нь Тээврийн цагдаагийн албаны алба хаагчид Монгол улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин хамгаалах эрхэм үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чанартай, шуурхай биелүүлж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эд материалын хохирлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлж, алба хаагчдаас үйл ажиллагаандаа мөрдөх чин эрмэлзэл нь "Бид замын хөдөлгөөнд оролцогчдын найдвартай туслагч, итгэлт түнш байх болно" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тээврийн цагдаагийн албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага, зохион байгуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах:

Тус алба нь улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, бодлого чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, түүгээр батлагдсан журам, заавар, Цагдаагийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны

төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах:

Тус алба иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 99488 дуудлага мэдээлэл хүлээн авсан. Гэмт хэргийн шинжтэй 71193 дуудлага, гомдол мэдээ мэдээллийг хүлээн авснаас 126 хүн нас барж, 3397 хүн гэмтсэн 2744 хэргийг материалжуулан хойшлуулшгүй ажиллагаа явуулж, эд материалын хохиролтой 19971 ослыг захиргааны хэрэг бүртгэлтэд шилжүүлсэн байна. Харьяа нэгж болон цагдаагийн бусад анги байгууллагуудаас зам тээврийн осол, хэрэг болон гэмт хэрэгт холбогдуулан шалгах шаардлагатай 1206 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг зарлан мэдээлж, 646 тээврийн хэрэгслийг саатуулан зогсоож холбогдох албадад шилжүүлсэн. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 15624, Хөдөлгөөнд оролцох шаардлага хангаагүй 6306 журамлагдсан тээврийн хэрэгслийн зөрчлийг бүртгэж, мөн цагдаагийн нийтлэг үүргээр 975 зөрчил, АСАП сангаас эрэн сурвалжлагдаж байгаа 1041 хүнийг илрүүлж, санд бүртгэн холбогдох албадад харьяаллын дагуу шилжүүлжээ. Нийслэл хотын гудамж замд байрлах замын хөдөлгөөний хэмжил-хяналтын төхөөрөмжөөр нийт 258479 зөрчил илрүүлэн баримтжуулж, холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуцлага оногдуулсан байна.

- Хамгаалалт, зохицуулалт

Тус албаны алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон гадаадын зочид төлөөлөгчид зорчих үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтад нийт 2698 удаагийн, давхардсан тоогоор 13236 хүн 127458 цагийн үүрэг гүйцэтгэсэн. Шинэ жил, Сар шинийн баяр, Хүүхдийн баяр, Автомашингүй өдөр, Олон улсын марафон гүйлт, Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын 2 дугаар бага хурал, Үндэсний их баяр наадам, Хүрээ-цам 2018 шашин, урлагийн наадам, Хичээлийн шинэ жил, Тусгаар тогтнолын баяр, “Үндэсний бахархлын өдөр” зэрэг олон нийтийг хамарсан баяр наадам, тэмдэглэлт ой, жагсаал цуглаан зохион байгуулагдах үеийн хамгаалалт, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Тайлангийн хугацаанд гадаад улс орнуудын төрийн өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн 1, 2, 3 дугаар зэрэглэлийн 19 хамгаалалт, гадаад улсаас Монгол Улсад суух элчин сайдуудаас Монгол Улсын Ерөнхийлөгчид итгэмжит жуух бичгээ барих үеийн 6 хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилласан.

- Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг олон нийтэд сурталчлан таниулах, цагдаагийн байгууллага, Тээврийн цагдаагийн албанаас явуулж байгаа бодлого, чиглэлийг олон нийтэд хүргэх зорилгоор 61 удаагийн уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэг, ажил, арга хэмжээ зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажилласан байна. Хэвлэл,

мэдээллийн 35 телевиз, 26 сайт, 15 ФМ радио, өдөр тутмын 5 сонинтой хамтран ажиллажээ. Телевизүүдэд 248 удаагийн 3720 минутын шууд болон зорилтот нэвтрүүлэг, 539 удаагийн 2695 минутын ярилцлага, 201 удаа буюу 502 минутын цаг үеийн нөхцөл байдлын болон осол, гэмтлийн шалтгаан нөхцөл, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг бэлтгэж, нэвтрүүлсэн байна. Замын хөдөлгөөний ачаалал, нөхцөл байдлын талаар болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зөвлөмж, мэдээллийг олон нийтэд тогтмол, шуурхай хүргэх зорилгоор нийт 732 удаа, 4780 минутын мэдээлэл, ярилцлага бэлтгэж хамтран ажилладаг ФМ радиогоор нэвтрүүлжээ.

Тээврийн цагдаагийн албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тээврийн цагдаагийн албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Тээврийн цагдаагийн алба нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Тээврийн цагдаагийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Тээврийн цагдаагийн албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 2* хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн Үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг суурь үзүүлэлт болгон 2 хувиар тооцов.

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны *Нийт зардал* 7,462,481.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 149,249.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 32 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/Мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	222,085.2	
2	Албан шаардлага өгсөн	1	0.00	
	Дүн	5	222,085.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитаар үндсэн хөрөнгөнд хэсэгчлэн тооллого хийхэд 5 ханатай гэр, 2 ширхэг модон ширээ, 2 ширхэг модон сандал тус албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2-т заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд дээрх үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах талаар албан шаардлага тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тээврийн цагдаагийн албаны данс бүртгэлд тусгагдаагүй хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа газрын талаар тодруулах.

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Тээврийн цагдаагийн алба нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 5,544,392.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 5,537,317.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь Батлагдсан төсөвт багтаан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 5,087,601.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 110,042.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсвийг 7,075.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 37,034.9 мянган төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 30,322.2 мянган төгрөг буюу 6,712.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Тээврийн цагдаагийн алба нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 6 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тээврийн цагдаагийн алба нь өмнөх онуудад аудитын түүвэрт хамрагдаж байсан учир тус албанд зөвлөмж, албан шаардлага, акт тогтоож байгаагүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Тээврийн цагдаагийн албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Цалин, ХХОАТ, НДШ талаар /үндсэн/

3.1.1 Илрүүлэлт:

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны үндсэн албан хаагчдын цалингийн тооцоолол болон бодолтыг шалган үзэхэд ХХОАТ 213.3 мянган төгрөгөөр дутуу, НДШ 38.8 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Цалин, ХХОАТ, НДШ талаар /гэрээт/

3.2.1 Илрүүлэлт:

Гэрээт цагдаагийн 160 алба хаагчийн цалинг Тээврийн цагдаагийн албанаас бодож байгаа боловч санхүүжилтийг Цагдаагийн ерөнхий газраас олгож байна. Үүнтэй холбоотойгоор ХХОАТ 158,990.0 мянган төгрөг, НДШ 43,023.7 мянган төгрөгөөр илүү төлсөн харагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасантай нийцэхгүй байна. Гэрээт цагдаагийн 160 алба хаагчийн цалинг Тээврийн цагдаагийн албанаас бодож байгаа боловч санхүүжилтийг Цагдаагийн ерөнхий газраас олгож байгаа асуудлыг шийдвэрлэх.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Зардлын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 591 мкв бүхий талбайг Сүхбаатар дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс ажлын байрны зориулалтаар ашиглах 2018 оны 010301 дугаартай түрээсийн гэрээ хийсэн байна. Тус гэрээний түрээсийн төлбөрийн тооцоог 2018 онд 46,360.4 мянган төгрөгөөр тооцсон боловч тус онд 59,467.1 мянган төгрөгийг төлсөн буюу 13,106.7 мянган төгрөгийг илүү төлсөн байна. Энэ нь 2017 онд хийсэн гэрээний төлбөрийн тооцооны дагуу төлөөгүй 13,106.7 мянган төгрөгийг 2017 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүйгээс үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан, залилан үүсэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Орлогын талаар

3.4.1 Илрүүлэлт:

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 37,034.9 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 30,322.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Нийт 6,712.7 мянган төгрөг буюу 18.1 хувийн тасралттай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Орлогыг үндэслэлтэй үнэн зөв төлөвлөөгүйгээс төлөвлөгөө биелэхгүй байх, төлөвлөгдсөн зардал дутуу санхүүжигдэх,

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	961,857,622.91	961,530,250.06
АВЛАГА	10,781,400.00	110,108.00
Ажиллагчидтай холбогдсон авлага		110,108.00
Татаас, санхүүжилтийн авлага	821,400.00	
Бусад авлага	9,960,000.00	-
Байгууллагаас авах авлага	9,960,000.00	-
УРЬДЧИЛГАА	832,015.92	648,526.00
Урьдчилгаа тооцоо	832,015.92	648,526.00
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	832,015.92	648,526.00
БАРАА МАТЕРИАЛ	950,244,206.99	960,771,616.06
Түүхий эд материал	690,727,389.26	668,240,111.36
Тусгай зориулалттай материал	690,727,389.26	666,240,111.36
Эм боох материал		2,000,000.00
Хангамжийн материал	253,900,617.73	286,684,504.70
Бичиг хэргийн материал	84,834,509.45	88,419,396.50
Аж ахуйн материал	16,379,420.00	17,883,970.00
Түлш, шатах тослох материал	17,457,223.87	23,106,000.00
Барилгын засварын материал	8,003,400.00	5,466,340.00
Бусад хангамжийн материал	127,226,064.41	151,808,798.20
Мал амьтад	5,616,200.00	5,847,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,550,376,784.41	2,582,298,119.82
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,550,376,784.41	2,582,298,119.82
Биет хөрөнгө	2,548,218,034.65	2,426,157,749.82
Барилга, байгууламж, орон сууц	2,055,494,536.00	1,918,014,624.00
Хуримтлагдсан элэгдэл	649,970,312.44	550,761,539.26
Авто-тээврийн хэрэгсэл	166,306,941.30	137,182,544.30
Хуримтлагдсан элэгдэл	145,154,128.65	131,577,544.24
Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,236,242,634.79	3,332,758,023.67
Хуримтлагдсан элэгдэл	2,469,421,437.39	2,618,243,245.28
Тавилга, аж ахуйн эд хогшил	218,890,717.64	216,968,958.13
Хуримтлагдсан элэгдэл	114,233,345.00	121,546,391.30
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,668,600.00	26,513,600.00
Бусад үндсэн хөрөнгө	434,943,791.28	437,021,491.28
Хуримтлагдсан элэгдэл	200,549,962.88	220,172,771.48
Биет бус хөрөнгө	2,158,749.76	156,140,370.00
Програм хангамж	30,038,000.00	37,960,000.00
Хуримтлагдсан элэгдэл	27,879,250.24	9,460,000.00
Бусад биет бус хөрөнгө		127,640,370.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,512,234,407.32	3,543,828,369.88
НИЙТ ӨР ТӨЛБӨР	821,400.00	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	821,400.00	-
Өглөг	821,400.00	-
Бусад өглөг	821,400.00	-
Байгууллагад төлөх өглөг	821,400.00	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,511,413,007.32	3,543,828,369.88
Засгийн газрын хувь оролцоо	3,511,413,007.32	3,543,828,369.88
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		127,640,370.00
Өмч: - төрийн		127,640,370.00
Хуримтлагдсан үр дүн	3,511,413,007.32	3,162,827,988.06
Өмнөх үеийн үр дүн	3,477,646,895.83	3,511,413,007.32
Тайлант үеийн үр дүн	33,766,111.49	- 348,585,019.26
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		253,360,011.82
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,512,234,407.32	3,543,828,369.88

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,587,958,519.69	7,113,896,220.40
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,948,639.69	848,105,754.40
Нийтлэг татварын бус орлого	315,948,639.69	848,105,754.40
Төсөвт байгууллагын өөрийн орлого	54,013,642.00	96,199,408.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		29,078,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,328,196.00	110,108.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,685,446.00	67,011,300.00
Бусад орлого	261,934,997.69	751,906,346.40
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,272,009,880.00	6,265,790,466.00
Улсын төвлөрсөн төсвөөс	5,505,665,300.00	5,507,357,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,505,665,300.00	5,507,357,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	705,530,580.00	758,432,566.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	8,188,400.00	47,372,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	662,787,180.00	96,497,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	32,000,000.00	609,501,737.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,555,000.00	5,061,829.00
Хөрөнгийн санхүүжилт	60,814,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	6,522,302,831.41	6,835,099,013.64
УРСГАЛ ЗАРДАЛ	6,406,557,259.41	6,835,099,013.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,406,557,259.41	6,824,603,841.14
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4,852,016,842.00	5,135,937,219.00
Цалин	3,983,364,742.00	4,311,061,077.00
Нэмэгдэл цалин	868,652,100.00	774,917,497.00
Урамшуулал	-	49,958,645.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,571,678.00	116,416,088.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,770,064.00	11,677,993.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	762,438.00	1,167,800.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	908,409.00	1,459,747.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	181,255.00	291,953.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	98,949,512.00	101,818,595.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,171,088.00	167,959,978.00
Гэрэл цахилгааны зардал	60,420,268.00	63,176,774.00
Түлш, халаалтын зардал	32,641,454.00	33,947,989.00
Цэвэр, бохир усны зардал	11,855,688.00	11,368,085.00
Байрны түрээс	33,253,678.00	59,467,130.00
Хангамж, бараа материалын зардал	450,200,755.00	645,143,570.05
Бичиг хэргийн материал	79,988,164.00	115,512,315.00
Тээвэр, шатахууны зардал	191,754,031.00	13,173,012.92
Шуудан холбоо интернетийн төлбөр	49,599,409.00	56,603,546.00
Ном хэвлэл		
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	33,161,905.00	25,594,450.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	95,697,246.00	243,446,610.44
Бараа материал актасны зардал	-	190,813,635.69
Нормативт зардал	75,570,608.00	166,660,732.00
Хоол	75,570,608.00	158,637,592.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,023,140.00
Эд хогшил, урсгал засварын зардал	51,924,146.00	23,504,281.00
Багаж хэрэгсэл		-
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		2,154,000.00
Урсгал засвар	51,924,146.00	21,350,281.00
Томилолт, зочны зардал	1,000,000.00	18,171,500.00
Гадаад томилолтын зардал	-	5,750,000.00
Дотоод томилолтын зардал	1,000,000.00	12,421,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	78,676,989.00	25,028,254.00

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,388,955.00	24,882,282.00
Газрын төлбөр	4,152,388.00	-
Улсын мэдээллийн маягтын зардал	135,646.00	145,972.00
Бараа үйлчилгээний бусад зардал	651,425,153.41	525,782,219.09
Бараа үйлчилгээний бусад зардал	3,784,500.00	126,429,190.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	434,561.50	3,972,365.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	647,206,091.91	395,380,664.09
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,745,572.00	10,495,172.50
Бусад урсгал шилжүүлэг	114,222,600.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114,222,600.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,522,972.00	10,495,172.50
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,205,000.00	362,296.50
Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	317,972.00	10,132,876.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	65,655,688.28	278,797,206.76
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	31,889,576.79	627,382,226.02
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	31,889,576.79	34,006,944.43
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	593,375,281.59
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(31,889,576.79)	(627,382,226.02)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	33,766,111.49	(348,585,019.26)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,237,507,345.00	6,296,924,055.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,490,065.00	30,322,189.00
Нийтлэг татварын бус орлого	25,490,065.00	30,322,189.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	25,490,065.00	30,322,189.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	30,322,189.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,490,065.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,212,017,280.00	6,266,601,866.00
Улсын төвлөрсөн төсвөөс	5,505,665,300.00	5,507,357,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,505,665,300.00	5,507,357,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	706,351,980.00	759,243,966.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	8,188,400.00	47,372,000.00
ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	662,787,180.00	96,497,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	32,000,000.00	609,501,737.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,376,400.00	5,873,229.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	5,929,556,745.00	6,045,725,555.00
УРСГАЛ ЗАРДАЛ	5,929,556,745.00	6,045,725,555.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,813,512,373.00	6,035,230,382.50
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4,862,388,154.00	5,137,560,059.00
Үндсэн цалин	3,993,736,054.00	2,631,721,771.00
Нэмэгдэл	868,652,100.00	2,455,879,643.00
Үр дүнгийн урамшуулал	-	49,958,645.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	96,534,700.00	116,037,437.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,824,433.00	23,525,837.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	708,069.00	-
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	908,409.00	-
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	181,255.00	-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	87,912,534.00	92,511,600.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	138,171,088.00	167,959,978.00
Гэрэл цахилгааны зардал	60,420,268.00	63,176,774.00
Түлш, халаалтын зардал	32,641,454.00	33,947,989.00
Цэвэр, бохир усны зардал	11,855,688.00	11,368,085.00
Байрны түрээс	33,253,678.00	59,467,130.00
Хангамж, бараа материалын зардал	289,491,857.00	151,952,653.50
Бичиг хэрэг	56,373,500.00	50,456,999.50
Тээвэр, шатахуун	166,835,460.00	26,193,808.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,733,009.00	51,971,046.00
Ном, хэвлэл	6,909,000.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,640,888.00	23,330,800.00
Нормативт зардал	75,728,980.00	186,452,652.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,000,000.00
Хоол, хүнс	75,298,980.00	156,957,592.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	27,495,060.00
Эд хогшил, урсгал засварын зардал	255,389,678.00	17,572,921.00
Багаж техник хэрэгсэл	235,852,120.00	-
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	2,995,000.00	3,000,000.00
Урсгал засвар	16,542,558.00	14,572,921.00
Томилолт, зочны зардал	1,000,000.00	18,171,500.00
Гадаад албан томилолт	-	5,750,000.00
Дотоод албан томилолт	1,000,000.00	12,421,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,607,916.00	18,555,582.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	90,455,528.00	18,555,582.00
Газрын төлбөр	4,152,388.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	220,967,600.00

Тээврийн цагдаагийн албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	-	215,501,100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	200,000.00	5,466,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,044,372.00	10,495,172.50
Бусад урсгал шилжүүлэг	113,700,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	113,700,000.00	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,344,372.00	10,495,172.50
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,205,000.00	362,296.50
Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	1,139,372.00	10,132,876.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	307,950,600.00	251,198,500.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	307,950,600.00	251,198,500.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	307,950,600.00	251,198,500.00
Дотоод эх үүсвэрээр	307,950,600.00	251,198,500.00
Бусад хөрөнгө	-	129,750,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	307,950,600.00	121,448,500.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	307,950,600.00	(251,198,500.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			3,477,646,895.83	3,477,646,895.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			3,477,646,895.83	3,477,646,895.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			33,766,111.49	33,766,111.49
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			3,511,413,007.32	3,511,413,007.32
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			3,511,413,007.32	3,511,413,007.32
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		253,360,011.82		253,360,011.82
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	127,640,370.00		-348,585,019.26	-220,944,649.26
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	127,640,370.00	253,360,011.82	3,162,827,988.06	3,543,828,369.88

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,544,392,800.00	5,537,317,792.50	7,075,007.50	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	5,544,392,800.00	5,537,317,792.50	7,075,007.50	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,544,392,800.00	5,537,317,792.50	7,075,007.50	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,087,623,500.00	5,087,601,414.00	22,086.00	100.0
Үндсэн цалин	3,101,141,200.00	2,631,721,771.00	469,419,429.00	84.9
Нэмэгдэл	1,986,482,300.00	2,455,879,643.00	-469,397,343.00	123.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,042,400.00	110,042,400.00	-	100.0
Тэтгэврийн даатгал		17,530,800.00	- 17,530,800.00	
Эрүүл мэндийн даатгал	110,042,400.00	92,511,600.00	17,530,800.00	84.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	167,968,800.00	167,959,978.00	8,822.00	100.0
Гэрэл, цахилгаан	63,177,400.00	63,176,774.00	626.00	100.0
Түлш, халаалт	33,769,100.00	33,947,989.00	- 178,889.00	100.5
Цэвэр, бохир ус	11,555,200.00	11,368,085.00	187,115.00	98.4
Байрны түрээс	59,467,100.00	59,467,130.00	- 30.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	90,472,300.00	88,362,845.50	2,109,454.50	97.7
Бичиг хэрэг	50,457,000.00	50,456,999.50	0.50	100.0
Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,863,000.00	15,035,046.00	1,827,954.00	89.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,152,300.00	17,870,800.00	281,500.00	98.4
Нормативт зардал	33,188,900.00	33,084,652.00	104,248.00	99.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Хоол, хүнс	29,179,800.00	29,075,592.00	104,208.00	99.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,009,100.00	2,009,060.00	40.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	27,033,500.00	27,022,921.00	10,579.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	9,450,000.00	9,450,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Урсгал засвар	14,583,500.00	14,572,921.00	10,579.00	99.9
Томилолт, зочны зардал	6,138,000.00	6,121,500.00	16,500.00	99.7
Дотоод албан томилолт	6,138,000.00	6,121,500.00	16,500.00	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,958,900.00	16,155,582.00	3,803,318.00	80.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,958,900.00	16,155,582.00	3,803,318.00	80.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,966,500.00	966,500.00	1,000,000.00	49.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00		1,000,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	966,500.00	966,500.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,544,392,800.00	5,537,317,792.50	7,075,007.50	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,507,357,900.00	5,506,995,603.50	362,296.50	100.0
Улсын төсвөөс санхүүжих	5,507,357,900.00	5,506,995,603.50	362,296.50	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	37,034,900.00	30,322,189.00	6,712,711.00	81.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,034,900.00	30,322,189.00	6,712,711.00	81.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	412.00	412.00	-	100.0
Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	391.00	391.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	17.00	17.00	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	412.0	412.0	-	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	395.00	395.00	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00	-	100.0

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:	САГ-2019/86/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Тээврийн цагдаагийн алба			мянган төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Цалин үндсэн	1	Тээврийн цагдаагийн албаны 2018 оны үндсэн албан хаагчдын цалингийн тооцоолол болон бодолтыг шалган үзэхэд ХХОАТ 213.3 мянган төгрөгөөр дутуу, НДШ 38.8 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.	252.1	Зөвлөмж өгсөн	2019.02.25	2019.02.25	Албаны дарга, цагдаагийн хурандаа	Д.Амарсайхан
2	Цалин /гэрээт/	2	Гэрээт цагдаагийн 160 алба хаагчийн цалинг Тээврийн цагдаагийн албанаас бодож байгаа боловч санхүүжилтийг Цагдаагийн ерөнхий газраас олгож байна. Үүнтэй холбоотойгоор ХХОАТ 158,990.0 мянган төгрөг, НДШ 43,023.7 мянган төгрөгөөр илүү төлсөн байна.	202,013.7	Зөвлөмж өгсөн	2019.02.25	2019.02.25	Албаны дарга, цагдаагийн хурандаа	Д.Амарсайхан
3	Орлого		Тээврийн цагдаагийн албаны 2018 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 37,034.9 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 30,322.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Нийт 6,712.7 мянган төгрөг буюу 18.1 хувийн тасралттай байна.	6,712.7	Зөвлөмж өгсөн	2019.02.25	2019.02.25	Албаны дарга, цагдаагийн хурандаа	Д.Амарсайхан
4	Зардал		Нийслэлийн өмчийн харилцааны газрын 591 кв бүхий талбайг Сүхбаатар дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс ажлын байрны зориулалтаар ашиглах 2018 оны 010301 дугаартай түрээсийн гэрээ хийсэн байна. Тус гэрээний түрээсийн төлбөрийн тооцоог 2018 онд 46,360.4 мянган төгрөгөөр тооцсон боловч тус онд 59,467.1 мянган төгрөгийг төлсөн буюу 13,106.7 мянган төгрөгийг илүү төлсөн байна. Энэ нь 2017 онд хийсэн гэрээний төлбөрийн тооцооны дагуу төлөөгүй 13,106.7 мянган төгрөгийг 2017 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүйгээс үүссэн байна.	13,106.7	Зөвлөмж өгсөн	2019.02.25	2019.02.25	Албаны дарга, цагдаагийн хурандаа	Д.Амарсайхан
5	Үндсэн хөрөнгө		Аудитаар үндсэн хөрөнгөнд хэсэгчлэн тооллого хийхэд 5 ханатай гэр, 2 ширхэг модон ширээ, 2 ширхэг модон сандал тус албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй байна. Иймд дээрх үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах.		Албан шаардлага өгөх	2019.02.25	2019.02.25	Албаны дарга, цагдаагийн хурандаа	Д.Амарсайхан

